



“Энэхүү бүтээлийг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд МУИС-ийн Хууль зүйн сургууль болон Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн багш, судлаач оюутнуудын баг хийж гүйцэтгэв. Бүтээлд илэрхийлэгдсэн агуулга, дүгнэлт, санал нь судлаачдын үзэл санаа бөгөөд АНУ-ын засгийн газар эсхүл дээрх агентлаг, хүрээлэн, сангийн албан ёсны байр суурь биш болно.”

2019 ОНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ БАТЛАГДСАН ҮЙЛ ЯВЦ:

Монгол улс анхны Үндсэн хуулиа 1924 баталж улмаар 1940, 1960, 1992 онуудад шинэчлэн баталсан. Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль нь шинэ, ардчилсан гэдгээрээ өмнөх гурван Үндсэн хуулиасаа онцлог юм. 6 бүлэг 70 зүйл, заалт бүхий 1992 оны Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал олон удаа яригдаж, хэлэлцэгдэж ирсэн боловч 2000 болон 2019 онд нэмэлт, өөрчлөлт орсон. Үндсэн хуулийн тогтвортой байдлыг хангах нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалтай салшгүй холбогддог тул Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа бусад хуулиас илүү хүндрүүлсэн журам баримталдаг. Нөгөөтээгүүр, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад ард түмний санал асуулга, иргэний нийгмийн байгууллагуудын санал, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын оролцоо, улс төрийн намуудын байр суурь зэргийг харгалзах шаардлага үүсдэг. Тухайлбал, 1999, 2000, 2006, 2011, 2012, 2015, 2017, 2019 онуудад Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал яригдаж, тухайн цаг бүрд УИХ-ын гишүүд төсөл өргөн мэдүүлж, зарим төслийг холбогдох байнгын хороогоор хэлэлцүүлж байсан түүхтэй. Эдгээр нэмэлт, өөрчлөлт оруулах санал, төслүүдээс 2019 оны 06 дугаар сарын 06-ний өдөр Д.Лүндээжанцан нарын 62 гишүүний өргөн мэдүүлсэн¹ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг онцлох нь зүйтэй. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн тус төслийг өргөн мэдүүлэхээс өмнө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдэд 2011-2019 онд ажлын хэсгийн судалгаа, зөвлөлдөх санал асуулга, бүсчилсэн хэлэлцүүлэг хэлбэрээр улсын хэмжээнд 21 аймаг, нийслэлийн хэмжээнд 69 удаа зохион байгуулагдаж хуулийн төслийг өргөн хүрээнд бэлтгэн хэлэлцсэн байна. Энэхүү судалгаагаар 2019 оны 6 дугаар сарын 06-ний өдөр Д.Лүндээжанцан нарын 62 гишүүний өргөн мэдүүлж, 2019 оны 11 сарын 14-ний өдөр батлагдсан “Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт”-ийг батлагдах хүртэлх үйл явцыг цаг хугацааны дарааллаар харуулахыг зорьсон болно.

¹ “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл өргөн мэдүүлэх тухай”, 2019 оны 6 сарын 06, 6293 тоот албан бичиг, Төрийн ордон

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдах хүртэлх үйл явц:

\Цаг хугацааны дарааллаар\

- 2011, 2012 онуудад Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага үүссэн тухай хууль тогтоогчид төдийгүй хуульч, эрдэмтэн судлаач, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн дунд байнга яригдаж, зарим иргэн, иргэний нийгмийн байгууллагаас Үндсэн хуулийн шинэ төслийг боловсруулж Улсын Их Хуралд ирүүлж байсан ба УИХ-ын зарим гишүүд Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл санаачилж байв.²
- 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их Хурлын даргын 27 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн дүгнэлт гаргав.³
- 2015 оны 11 сарын 6-нд Улсын Их Хурлын даргын 08 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулан УИХ-д өргөн барив.⁴ Тухайн үеийн УИХ бүрэн эрхийнхээ хугацаанд хэлэлцэн баталж амжаагүй.
- 2016 оны 12 сарын 21-ний өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын захирамжаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг судлах зорилгоор эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн ажлын хэсэг байгуулсан бөгөөд ажлын хэсгийн судалгааны үр дүнд Үндсэн хуулийн зарим зүйл, хэсэг, заалтад нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн дүгнэлт гарсан. Тус ажлын хэсгээс үндэслэл тайлбар бүхий 46 заалттай тайлан, санал дүгнэлт гаргасан.⁵
- 2017 оны 4 дүгээр сарын 7-ний өдөр “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах, зөвлөлдөх зөвлөл байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 24 дүгээр тогтоол гарав.⁶ Зөвлөлдөх зөвлөл нь Ц.Гомбосүрэн (Гадаад хэргийн сайд асан), Н.Жанцанноров (Монгол Улсын Соёл, урлагийн их сургуулийн тэргүүлэх профессор), Д.Ламжав (Үндсэн хууль судлаач, Улсын Бага Хурлын гишүүн асан), Б.Лхагважав (Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч), Ц.Сарантуяа (Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн сургуулийн багш, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор), Д.Сүхжаргалмаа ("Монфемнет Үндэсний сүлжээ" ТББ-ын зөвлөх), Д.Чойжамц (Монголын Бурхан Шашинтны Төв Гандантэгчэнлин хийдийн тэргүүн

² Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн танилцуулга”, Д.Лүндээжанцан нарын хууль санаачлагчид, 2019 оны 6 дугаар сарын 6-ний өдөр, <https://forum.parliament.mn/projects/612>

³ “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал”, Д.Лүндээжанцан нарын хууль санаачлагчид, 2019 оны 6 сарын 6-ний өдөр, <https://forum.parliament.mn/projects/612>

⁴ “Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ”, Улсын Их Хурал, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), 2016 он, 171 дэх тал

⁵ “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал”, Д.Лүндээжанцан нарын хууль санаачлагчид, 2019 оны 6 сарын 6-ний өдөр, <https://forum.parliament.mn/projects/612>

⁶ 2017 оны 4 дүгээр сарын 7-ний өдрийн Монгол Улсын Их Хурлын 24 дүгээр тогтоол, <https://legainfo.mn/mn/detail/12575>

- хамба лам, Ардын Их Хурлын депутат асан), Г.Чулуунбаатар (Монгол Улсын Шинжлэх ухааны академийн тэргүүн дэд ерөнхийлөгч) нарын бүрэлдэхүүнтэй байв.⁷
- Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн дагуу УИХ-ын 2017 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор “Зөвлөлдөх зөвлөл” байгуулж, 6 багц асуудлаар зөвлөлдөх санал асуулга явуулж 5 багц асуудал нь дэмжигдсэн.
 - 2017 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын даргын 78 дугаар захирамжаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулав. Тус ажлын хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн хүрээнд Зөвлөлдөх санал асуулгаар дэмжигдсэн 5 багц асуудлаар 22 заалт бүхий төсөл боловсруулсан.
 - 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулах ажлын хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газраас санал хүргүүлэв.⁸
 - Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 5 багц, 22 заалт бүхий төсөлд иргэдийн саналыг авах үүднээс Монгол Улсын Их Хурлын 2017 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдав.
 - 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Улсын Их Хурлын даргын 107 дугаар захирамжаар олон нийтийн хэлэлцүүлгийг улсын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдав.⁹
 - 2017 оны 7 дугаар сараас 12 дугаар сарын хооронд 21 аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 68 удаагийн бүсчилсэн хэлэлцүүлэг зохион байгуулж, улсын хэмжээнд 327375 иргэнээс 5.584.832 нэгж санал хүлээн авав.¹⁰
 - Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсгээс “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах онол-практикийн асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, бусад байгууллагаас “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх” асуудлаар 10 орчим эрдэм шинжилгээний хурал хэлэлцүүлэх зохион байгуулжээ.
 - 2017 оноос 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн судалгаа, шинжилгээнүүд хийгдэж 2019 оны 6 дугаар сарын 06-ний өдөр Д.Лүндээжанцан

⁷ “Монгол Улсын Үндсэн Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах сэдвийн танилцуулга”, Монгол Улсын Их Хурал, 2017 он, [Сүүлд үзсэн: 2022.09.02]
https://cdd.stanford.edu/mm/2017/08/BriefingDocument_MongolianApr2017.pdf

⁸ “Санал хүргүүлэх тухай”, 2017 оны 5 сарын 18, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгийн газар, ТГ/ 273 тоот албан бичиг, <https://forum.parliament.mn/projects/612>

⁹ “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал”, Д.Лүндээжанцан нарын хууль санаачлагчид, 2019 оны 6 дугаар сарын 6-ний өдөр, <https://forum.parliament.mn/projects/612>

¹⁰ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн танилцуулга”, Д.Лүндээжанцан нарын хууль санаачлагчид, 2019 оны 6 дугаар сарын 6-ний өдөр, <https://forum.parliament.mn/projects/612>

нарын 62 гишүүн “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулан Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэв.”¹¹

- 2019 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг буюу хэлэлцэх эсэх асуудлыг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэв.
- Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын нэр бүхий 62 гишүүнээс санаачлан боловсруулж, 2019 оны 6-р сарын 06-ны өдөр Улсын Их хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5.1, 5.3-р зүйлд заасан зарчим, УИХ-ын даргын 2019 оны 159-р захирамжаар өгсөн чиглэлийн дагуу иргэд, олон нийтэд таниулах, мэдээллээр хангах, санал авах ажлыг 2019 оны 6-р сарын 19-ны өдрөөс 30-ны өдрүүдэд зохион байгуулсан.
- 2019 оны 6 дугаар сарын 14, 18-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн нэг дэх хэлэлцүүлгийг хийж төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.
- 2019 оны 7 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24⁴ дүгээр зүйлийн 24⁴.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдөр Хууль зүйн байнгын хороо тус тус төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудлыг хэлэлцэв.¹²
- Монгол Улсын Их Хурлын 2019 оны 68 дугаар тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хоёр, гуравдах хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гарсныг Байнгын хороонд Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Ө.Энхтүвшин танилцуулав.
- 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдөр “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл”, “Шүүхийн Ерөнхий зөвлөл”, “Үндсэн хуулийн цэц”, “Улсын Дээд Шүүх”, “Засгийн газрын хэрэг эрхлэх газар”, “Хүний Эрхийн Үндэсний Комисс”, “Монгол Банк” зэрэг байгууллагуудаас Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд санал хүргүүлэв.¹³

¹¹ “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл өргөн мэдүүлэх тухай”, 2019 оны 6 сарын 06, 6293 тоот албан бичиг, Төрийн ордон

¹² “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд харьяалагдах байнгын хороодоос өгсөн дүгнэлт”, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, <https://forum.parliament.mn/projects/612>

¹³ “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд төсөл санаачлагч болон байгууллагуудаас ирүүлсэн албан бичиг” Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, <https://forum.parliament.mn/projects/612>

- 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, саналаа танилцуулав.¹⁴
- 2019 оны 8 дугаар сарын 28, 29, 9 дүгээр сарын 04, 05, 07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж, төслийг ард нийтийн санал асуулгад оруулах нь зүйтэй гэж УИХ-ын нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь тогтсон тул Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн дагуу ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолыг батлав.
- Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай УИХ-ын 73 дугаар тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2019 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавив.¹⁵
- Ерөнхийлөгчийг хоригийг УИХ-ын 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авах нь зүйтэй гэж үзэж “Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай” УИХ-ын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолыг хүчингүй болгов.¹⁶
- 2019 оны 11 сарын 13-ны өдөр Төрийн байгуулалтын байнгын хороо “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийв.¹⁷
- 2019 оны 11 сарын 14-ний өдөр УИХ-ын нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийж төслийг бүхэлд нь батлах санал хураалтыг илээр гар өргөж явуулахад чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон 63 гишүүн санал нэгтэй дэмжиж, 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 18 цагт Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл эцэслэн батлагдав.¹⁸

Бэлтгэсэн:

Б. Сарантуяа

2022 оны 8 дугаар сарын 30

¹⁴ “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, санал”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, <https://forum.parliament.mn/projects/10640>

¹⁵ “Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 73 дугаар тогтоолд хориг тавив”, Хориг тавих тухай албан бичиг, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын Тамгын газар, 2019 оны 9 дүгээр сарын 20-ний өдөр, <https://president.mn/10965/>

¹⁶ “Монгол Улсын үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн гуравдахь хэлэлцүүлэг”, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан, <https://parliament.mn/n/uxky>

¹⁷ Мөн тэнд,

¹⁸ “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг эцэслэн батлав”, Улсын Их Хурлын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс, 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр <https://parliament.mn/n/uxky>